

ЙӨНШӨӨБҮ РИ... БАГШТАН ЮУГААН ДУРСАХЫН УЧИР* ...

Ц.Шагдарсүрэн

ТАТАЛ ҮГ: 1970 онд *Залуучуудын Үнэн* сонины сурвалжлагч “энэ агшинд сэтгэлдээ буусан нэг бадаг шүлэг бичнэ үү” гэхэд Ринчен багштан ийнхүү бичжээ:

***Өнгөт ертөнцөд сайхан газар олон буй
Өлгий нутагаас минь сайхан газар үгүй.
Эрдэм сурахад хэл бүхэн сайхан буй
Эх хэлий минь гүйцэх сайхан хэл үгүй.***

Бага байхад аав маань намайг дагуулаад хамба лам Эрдэнэпэл, түүхч, манжич Л. Дэндэв, Номын сангийн сахалт Лувсандорж, (Ц. Дамдинсүрэн гуайн хуурай эцэг) өвгөн Буяндэлгэр зэрэг номын садан танил нөхдийндөө очиж үүх түүх шашин номын явдал, Бурхан багшийн мэндэлсний 2500 жилийн ой, монгол хэл зохиолын талаар хууч хөөрөхөд нь би гэдэг хүн тэр бүр яриаг ухаж мэдэхгүй боловч сонирхон соносч тавгийн чихэр, балингийн гурилаас нь амтархан идэж, сонин зураг хөрөгтэй номоос нь эргүүлж суудаг байж билээ.

Мянга есөн зуун тавин хэдэн оны эхээр нэгэн сайн өдөр аав намайг дагуулж, их сургуулийн хавьд эрдэмтэн Ринченийд очсон нь миний хувьд их эрдэмтний өргөө гэрт нь анх орж, хожимынхоо багшийн гэгээн дүрийг анх харах өлзий учралыг бүрдүүлж дээ гэж би одоо санадаг. Үзээгүй олон номын дунд суудаг, бахдаж бишрэм сүрлэг сайхан дүртэй тэр хүн аавтай минь баахан ярьж хөөрөөд явахад маань “*манай босгыг анх алхаж, орж ирж байгаа хүн*” гээд “*номтой хүн болоорой*” гэж ерөөн над цэнхэр хайрцагтай, алт шармал дотортой, кавказ мөнгөн хундагад үзэм чихэр хийж өгсөн бөгөөд аав ээж хоёр минь ч бэлгэшээн хадгалсаар ирсэн нь одоо ч надад бий.

Ингээд 1962 онд МУИС-д элсэн орох үест элсэлтийн комиссынхин тоо физикийн ангид ор! гэхэд нь ааваараа баахан хөөцөлдүүлэн байж монгол хэл, уран зохиолын ангид бүртгүүлж, элсэн ороод хавар нь ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн хэл аялгуу угсаатны зүйн шинжээний ангид туслах ажилтнаар оролцох болж шалгалтаа түрүүлж өгөөд Хэнтий, Дорнод аймгаар хоёр сар шахам явахад уг шинжээний ангийг академич профессор Ринчен доктор тэргүүлж явсан билээ. Үүнээс хойш энэ мэтээр академичийн удирдсан шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд хэдэн зун дараалан оролцож 10 гаруй аймгаар явсан асан.

1967 онд МУИС-ийг дүүргэх тэр үед ахмад үеийнхний саналын дагуу хэл зохиолын салбарын гурван академичид дагалдуулан сургах гарын шавийн орон тоо буй болгох тухай шийдвэр гараад 2 жил шахам болоод байсан тул багш минь боломжийн байж магадгүй гэж санасан юм болов уу даа, намайг гололгүй гарынхаа шавиар авсан юм даа. Ийнхүү 1963 оноос академич, профессор Ринчен доктортой багш шавийн барилдлагатай болж ертөнцийн мөнх бусыг үзүүлтэл нь 15 жил дагалдан ойр дотно ажиллаж ном эрдмийн шимээс нь хүртэж билээ би.

* 2004 онд *Монголын Шинжлэх Ухаан* цувралын 5-р ботиор гарсан *Бямбын Ринчен* номд орсон дурадхал дээр нэлээд баримт мэдээг нэмсэн болно.

15 жил гэдэг нэг бодлын урт хугацаа. Гэлээ ч одоо эргээд санахад юутай түргэн өнгөрөөв дээ!. Багш минь нас элээд бас гучаад жил болчихсон байдаг. Цаг хугацаа гэдэг л үнэн мөний гэгээн шүүгч юм уу даа гэж эрхгүй санагддаг.

1973 оны 5-р сарын 8-нд *“Төв Азийн соёл иргэншилд нүүдэлчдийн оруулсан хувь нэмэр”* гэдэг ситпозиум буюу олон улсын хам илтгэлт хуралд тавьж хэлэлцүүлсэн илтгэлдээ багш минь *“...монголчуудын соёл боловсролын тухай мэдэх мэдэхгүй амьтнаар элдэвлүүлэн бичүүлсэн түүхтэй улс энэ дэлхий дээр монголчуудаас өөр байхгүй гэж санагдаж байна...”* гэж хэлсэн билээ. Үүнчилэн хүний хувьд японы тагнуул, хувьсгалын эсэргүү, цагаачин, феодалын үеийг магтагч, жижиг хөрөнгөтний үзэлтэн, зөвлөлтийн эрдэмтдийг шүүмжлэн монгол, зөвлөлтийн найрамдлыг хялайн үзэгч, социалист монголын хөгжилгийг үгүйсгэгч гэх зэргээр зүсэн бүрээр хэлүүлээд зогссонгүй, эцэг эх, ах дүүгээ хүртэл хүний ёсноос гадуур элдэвлүүлэн гүтгүүлж, таван жил шоронд хилс хэргийн учир хэлмэгдэн хоригдож бие сэтгэл, эрүүл мэндийн хувьд үлэмжхэн хохирч, толгойдоо зандалчны гансаар цоо цохиулсан цоорхойтой, бугуйдаа төмөр утсаар эрүүлсний гялгар цагаан сорвитой гарч ирсэн, тухайн цагтаа хязгааргүй эрх мэдэл бүхий намын төв хэвлэлүүдэд гарсан эзэн зохиогчгүй өгүүллэгээр ёсон бусаар гурвантаа дайран гүтгүүлсэн хүн ер нь бий л болов уу даа?! Тэгээд бас болоогүй, ном зохиолоо шатаалгаж, хэвлэн нийтлүүлэх, хувийн захидлын нууцаа хуулиар хамгаалуулах, олон жилийн өмнө орчуулсан ном зохиолоо хүртэл нийтийн хүртээл болгох зэрэг хүний эрх мэдлийн наад захын эрхээ насан эцэслэглээ хасуулсан байсныг мартахын аргагүй. 1967-1977 онд буюу амар заяа бараг үзүүлээгүй амьдралынх нь сүүлийн арван жилд багштайгаа нэг хүрээлэнд эрдэм номын удирдлагад нь ажиллаж, нэг байранд хөрш сууж, хөдөө гадаагүй дагаж ойр дотно байсны хувьд тэр цагийн зүдэг хар үйлийн талаар товч боловч дурдах нь зүйтэй гэж сананам. 1960 хэдэн оноос хоосон нэр горилогч хэсэг хүмүүс академичийн эсрэг бас нэгэн ээлжит аян дайнд нэгдэж, нэр төрий нь унагалаа гэж итгэн баясч, “нэрт” удирдагчдаасаа хайр шан хүртэж, өндөр зэрэг, цол олсон боловч чухамдаа юмны наад цаадыг мэддэг, өргөн олны дунд их эрдэмтнийг хүндэтгэх сэтгэлийг улам сэргээж харин ч өөрсдийнхөө яс тарыг таниулснаа огтхон ч ойлгоогүй юм.

Албан тушаал шунан горилогчид *“суусан газараасаа шороо атгах”* бол омж гарлаа гэж нэгэн хэсэг нь Ринчентэй зэрэгцэн суулаа гэж “нөхөр”-төө анхааруулж (энэ тухай “Сэтгүүлч” сэтгүүлийн 1989 оны 2-рт Г. Жамсранжав авгайн бичсэнийг 55- талаас үзмүү) нөгөө зарим нь академичтай албан хэргээр уулзсан хүнийг хүртэл “үндэсний үзэлтний” дансанд тэмдэглэж (энэ тухай Хөдөлмөр сонины 1990 оны 6-рт С. Жамбалдоржийн бичсэнийг 4-р нүүрээс үзмүү), тэр үед монгол хэл зохиолын салбараар Хэл зохиолын хүрээлэнд эрдмийн зэрэг хамгаалсан хүмүүс болзолын шалгалт өгөхийн хажуугаар академич Ринченг ямар нэг хэмжээгээр нийтийн өмнө буюу зохиолдоо, эс бөгөөс сонин сэтгүүлд шүүмжилж байж сая зэрэг хамгаалах “эрх”-тэй болдог байсан гэдэг яриа үнэн байсан билээ. Цаг урин болоход мөнөөхи хүмүүсийн зарим нь одоо “шавь” нь байсан болж *“сайн хүний нэрийг долоо худалдаж иддэг”* гэдэг үгээр сонин хэвлэлийн газараас хэд гурван мөнгө олж амьдралдаа нэмэрлээд байгаа юм. Харин нэг хэсэг нь хуучин янзаараа “үзэл бодол”-доо үнэнч хэвээр байж академичийн наснаас нөхөцсөн өдөрий нь ч мартаж чадалгүй тэр өдөрий нь тааруулж ид мандаж явахдаа өмсгөж байсан мөнөөх аюумшигийн *“хар малгай”*-гаа өмсгөх гэж эрмэлзэн (энэ тухай *“Үнэн”* сонины 1989 оны 3-р сарын 4-ний 54-рийн 5-р нүүрээс үзмүү) ёсон бусчилсаар байлаа.

Багшийг тэнгэрт халисаны дараа зарим нэг томоос томд тооцогддог эрдэмтэн хүн хүртэл, уг хэвлэгдсэн номдоо цагаан цаасан дээр хар үсэгээр дурайтал Ринчен гэж байсаар байтал орчуулсан бүтээл, хянан тохиолдуулсан ажилы нь минийхи гэж Олон Улсын Их хуралд илтгэл тавьсан баримт ч гарч л байлаа. Хэвлэгдсэн ном хэдий эртнийхи, хэдий ховордсон ч гэсэн хаа нэгтээгээс олдож л таарна. Бас гадаадын зарим зохиолыг хэрхин монголчилосон тухайгаа нийтийн хэвлэлд удаа дараа бичсэн байтал нь орчуулаагүй гэх буюу өөр хүнтэй хамжиж орчуулсан болгох гэсэн судлагааны бүтээл ч гарч амжжээ.

Бас сүүлийн үес хүмүүсийг мартсан гэж бодсон ч юм уу, багшийн минь нэрийг элдэв зүйлд холбогдуулан ярих явдал ч гарсаар байна. Монгол бичгийг халуулахгүйн төлөө багш минь Н. С. Хрущев, Мао Це-дүн нарт зоримог захиа бичиж байсан, хэзээ ч эргэж буцаж яваагүй. Гэтэл манай нэг эрдэмтэн 1941 онд Чойбалсан манай гурван томыг (Дамдинсүрэн, Ринчен, Лувсанвандан) дуудаж монгол бичгийн оронд латин, орос үсгийн алийг нь авах вэ? гэхэд "латины 26 үсэг монгол хэлний 35 авиаг тэмдэглэхэд хүрэхгүй учир" цөмөөрөө орос үсгийг нь санал нэгтэй сонгосон гэж зурагтаар ярьж байх юм. Энэ үед "шинэ" үсгээс өөр үсгийг сонгох улс төрийн боломж байгаагүйг судласаны хувьд би батлана. Бас 1941 онд Ри багштан Чойбалсантай уулзаж санал өгөх битгий хэл, шоронд цаазлуулах ялтай сууж байсан билээ. Ринчен багштан 1937 оны 9-р сарын 10-аас 1942 оны 4-р сар болтол шоронд сууж байхад нь Чойбалсан гуай Ц. Дамдинсүрэн, Ш. Лувсанвандан нартай хамтад нь урьж саналы нь аваагүй нь мэдээж. Зохиол бүтээлдээ Монголын "за" андагаар буй заа ("за" гэсэн бол андгай тавьсантай адил) гэдэг уламжлалт хэлэлгийг нэг бус дурдаж, түүнийгээ чанд баримтлан явсан багш маань улааныг үзэн урваж, шарыг үзэн шарваж яваагүй.

| | |
|---|---|
| <p>ҮНЭМЛЭХ</p> <p><u>Бянда</u> овогтой</p> <p><u>Ринчен</u> 1937 онд улс төрийн гэмт хэрэгт шийтгэгдснийг хянаж үзээд БНМА Улсын Дээд Шүүхийн Бүгд Хурлын 1963 оны 4-р сарын 5-өдрийн 025-р тогтоолоор уг хэрэгт холбогдолгүй болгож цагаалгав.</p> | <p><u>Ринчен</u> — ны 1937 оны 9-р сарын 10-нээс 1942 оны 4-р сарын 10-н хүртэл хоригдсон хугацааг улсад тасралтгүй эжилдсэнийг тооцоно.</p> <p>БНМА Улсын Дээд Шүүхийн дэргэ</p> <p>1963 он 4-р сарын 5-өдөр</p> |
|---|---|

Бас нэгэн зүйл: "Цогт тайж" кино зохиолыг нэгд, найруулагч нь орос хүн байсантай, хоёрт, тухайн үед тийм кино хийхэд орос сургагчаас эхлээд танилцах үзэх янз бүрийн зэргэмжийн орос хүн байх нь мэдээж тул багш минь монгол, орос хэлээр зэрэг бичсэн билээ (Надад машиндмал монгол эх, орос орчуулгын хуулбар нь байгаа). Бусад зохиол бүтээлээ ч хэд хэдэн хэлээр зэрэг (орчуулан) бичдэгийг хэн бүхэн андахгүй. Гэтэл манай зурагтаар уг кино бүтээхэд оролцсон жүжигчид болон бас бус киноны хүмүүсийг цуглуулан яриулахад, тэр үед Зөвлөлтөд киноны сургуульд оюутан байсан, оросоор орчуулж, дуу оруулахад оролцсон тухайгаа ярьж байхыг сонсолоо.

Бас нэгэн зүйл: сүүлийн үед олон ном дахин хэвлэгдэх болжээ. Тийм нэг бус номыг үзэж суухнаа, социализмын үеийн анхны хэвлэлд нь багшийг минь үзэл сурталаар элдэвээр лантуудаж тэр цагтаа нэр төр олж байсан хэсэгийг нь тухайн зохиогч нь төдийгүй, дахиж хэвлэлд бэлэдсэн, тэдний шавь нар нь аваад хаячихсан байх ажээ. Дэлхийгээр нэг тарсан анхны хэвлэлийг нь бүрмөсөн устгаагүй цагт, бас олон юм үзэж нүд тайлсан, юуг ч мартдаггүй цээж сайн эрхэм уншигчидыг дорд үзэж болохгүй.

¹ Цагаан толгойн үсэг олон байх нь заавал боловсронгуйн шинж биш. Хэлшинжлэлийн салбар болох үсэгзүйн ухаанд дан үсэг, нийлмэл үсэг, нийлэмж үсэг, нэмэлт тэмдэг бүхий үсэг гэж байх бөгөөд энэ бүхэн нь тухайн цагаан толгойн бүтэц бүрэлдэхүүнийг дэлгэрүүлэх боломж олгодог гэдэгийг бид франц, чех, герман цагаан толгойноос бэлхэнээ харж болно.

Харин аливаа юмны үнэн мөнийг дүгнэн цэгнэх чадалтай шударгуу шүүгч болсон олон түмэн, жинхэнэ ном эрдмийн зам мөрийг хөөсөн номын садан-дотоод гадаадын эрдэмтэн нөхөд нь, журамыг барьсан олон шавь нар нь ёсон бусчилагчдаас огт өөрөөр үзэж хайрлан хүндэтгэсээр байсаныг эс дурдвал хилэнц болох буй заа.

Ринчен багш маань яагаад “дээд дарга” нарын санаанд нь нийцдэггүй байсны учир утгын талаар эргэцүүлж бодсоноо ярихын өмнө уламжлалт дурсамж, дуртгалын загварт хэсэгхэн орж, энэ их бичигийн хүний талаар уншигч авгай нарт сургаалтай бөгөөд хэрэг болуужин гэсэн сэтгэлийн үүднээс цөөн хэдэн зүйлийг ярьсу.

Эрдэм номын ажлыг хийхэд аль нэгэн салбарыг гэлтгүй, харилцан холбоотой бөгөөд шүтэн барилдсан ухаан бүрийг нэгэн адил үзэж судлахыг чухалчилдаг байсан тул эрдэм шинжилгээний хүрээнд гэхэд л монголын судлалын бараг бүхий л салбарыг тухайлбал: монгол хэл аялгуу, түүх соёл, утга зохиол, ардын билиг, угсаатны зүй, бөө судлал, утга соёл, эдийн боловсрол зэрэг олон сэдэв зүйлээр бүтээл номоо туурвиж байсан билээ. Харин өөнтүүлэгч нар л эрдэм шинжилгээний хувьд өргөн хүрээтэй байна гэдэг бол тодорхой нэгэн зүйл рүү гүнзгийрэхгүй болдог гэж “онолдож” ирсэн нь өөрсдийнх нь “хэмжүүр” байснаас биш Ринчен багшийн маань хувьд таарсан “хэмжүүр” болж чадаагүй юм. Ямар ч байсан дээр дурдсан олон салбараар бичиж туурвисан ном бүтээл нь тоо хэмжээгээрээ ч, эрдэм шинжилгээний үндэслэл, баримт сэлт, дүгнэлтээрээ ганц нэг зүйлд “гүнзгийрсэн эрдэмтнийхээс” ч ямагт илүү дээгүүр байдаг байсан нь үүний баталгаа буюу.

Академич профессор Ринчен доктор эрдэм номын мөр хөөсөн шавь нартаа гадаад хэл үзэж сурахын зэрэгцээ судалгааны ажилд зайлшгүй хэрэг болдог зүйл, тухайлбал; гар зураг зурах, гэрэл зураг татах, түүнийгээ буулгах, дуу хураагуурт хэл аялгуу, ардын билгийн хэрэглэгдэхүүн шингээж авах, хад чулууны бичээс зурагийн хэв дардас авах, дуу хуурын ая данг тэмдэглэх, бичиж зохиосон зүйлээ өөрөө орчуулдаг, өөрөө машиндаж цохидог болох зэрэгээр бусдын гар харж, цаг зав алдахгүй байхыг ямагт хичээлтүн! хэмээж сургадагсан. Тэгээд ч одоогийн “зарим багш, удирдагч” шиг судалгааны хэрэглэгдэхүүнээ шавиараа цуглуулуулж, юмаа машиндуулах, орчуулгах, шавийнхи нь бичсэн зүйл сонин санагдвал саналаа нэмэрлэсэн гэж зохиогчоор нэрээ өмнө нь тавих зэрэгээр багш гэдгээрээ далайлган “ашиглаж” байсан явдал нэгээхэн бээр үгүй.

Одоо манайхан гадаад хэл сурч мэдэхийн ач тусыг сая нэг яс махаараа мэдэж хичээн шимтэх боллоо. Иймээс гадаад хэл үзэхийн тухайд багш маань хэрхэн сануулж сургаж байсныг арай дэлгэрхэн дурдъя гэж бодлоо. Академичийн бичсэн зүйл дотор “*Өрлүгээ манагаар үхэх боловч өрсөж юм сур!*” гэдэг монгол ардын сургаал үгийг татал болгож хэрэглэсэн нь олонтаа дайралддаг. Энэхүү сайхан хэлэлгийг насан туршдаа баримталж явсныг эрдэм боловсрол нь, ном бүтээл нь, үйл ажил нь бэлхэнээ гэрчилдэг. Юм сурна, тэр дундаа гадаад хэл сурна гэдэг бол тавтай боллоцоо, зай зав гарахыг хүлээдэг зүйл огтхон биш гэдгийг их эрдэмтний ажил амьдралын туршилга аяндаа хэлж өгнө. Ганц нэг баримт дурдсу. Японы тагнуул, эсэргүү гэгдэж 1937-1942 онд шоронд хоригдож, үхлийн ирмэг дээр байхдаа нэгэн өдөр, том гантай ялгадас дамнан гаргаж асгахаар явтал хашаан доторх зуухны дэргэд шатаахаар овоолсон “эсэргүү” номын дундаас товхгордуу нэг ном нүдэнд нь туссан гэдэг. Түүнийг ухасхийж аваад үзвэл франц хэлний сурах бичиг байсан ажээ. Дагаж явсан хуяг нь зандрхад “*дотор бөгс арчих цаас олдохгүй юм*” гээд аргалж авч ороод, үзэн үзэсээр франц хэлтэй болж шоронгоос гарсан бөгөөд сүүлд монголын судлалын олон салбараар гадаадад нийтлүүлсэн бүтээлийн дийлэнхи олон нь франц хэлээр байсан билээ. Бие нь чилээрхэж насан өөд болтлоо багш маань эртний латин, хятад хэл үзэсээр байсныг би лавтай мэдэж байна.

Уулзаж учирсан хэнд ч болов, ялангуяа эрдэм номын мөр хөөсүгэй гэсэн хүнд багш маань зөвлөн сануулахдаа эх монгол хэлээ гүнзгий сайн мэдэхийн сацуу боловсрол мэдлэгийн нүд нээж, ухаан тэлэхэд гадаад хэл нэн чухал бөгөөд монголыг судлалч эрдэмтэн хүний хувьд наад зах нь *судалгааны дөрвөн хэл* (буюу судлагдахуун болдог түрэг, манж, төвд, хятад хэл), *шинжилгээний дөрвөн хэл* (буюу ном зохиолоо бичин нийтлүүлэхээс гадна бусад эрдэмтний бүтээлтэй танилцахад давын өмнө хэрэгтэй болдог англи, франц, орос, герман хэл)-ийг зайлшгүй сураад зогсохгүй дундад

зууны үед европ дахины номын хэл болж байсан латин хэл, мөн төв ази дахинаа эрт цагт хэрэглэгдэж байсан, энэтхэг-европын овог хэлний өвөг болсон самгард хэлийг үзэхгүй бол яав ч болохгүй гэж захидаг асан. Зөвхөн ингэж захиад зогсдоггүй, шавь нараасаа эрдэм шинжилгээний зохиол бүтээлээ гадаад хэлээр бичиж хэвлэн нийтлүүлэх нь монгол ардынхаа утга соёлын түүхийг дэлхий нийтийн шинжлэх ухааны эргэлтэд оруулж байгаа хэрэг гэж шинжилгээний дөрвөн хэлээр, эс ядаж аль нэгээр нь бичиж сурахыг чандлан шаарддаг байсан билээ.

Гадаад хэл сурах, гадаад хэлээр бичдэг хэмжээнд хүрэхэд өдөр бүр тогтмол оролдож хэвших, үзэж байгаа хэлээрээ сэтгэж сурах, тухайлбал, унаа тэргэнд нэг аятайхан бүсгүй явж байлаа гэхэд сурч байгаа хэлээрээ "ямар аятайхан бүсгүй вэ?" гэдгийг юу гэж хэлдэг билээ гэж бодож үзэх, хэрэвзээ санаанд орж өгөхгүй бол марталгүй яваад харьсан хойноо толь бичиг, ном сурахаасаа үзээд авах хэрэгтэй, тэгж үзсэн юм авад мартагдахгүй. Энэ мэтээр харсан, үзсэн, бодсон юмаа тэр хэлээрээ сэтгэх хэрэгтэй. Бичиж сурах тухайд бол, эхэн үедээ бичье гэсэн сэдвээрээ өдөр өнжихгүй, хэлзүйн ном, толь бичиг үзээд 3 өгүүлбэр тавиад байхад сард доод зах нь 90 өгүүлбэртэй болчихсон байх бий. Энэ мэтээр өгүүлбэрийнхээ тоог ахиулаад байх хэрэгтэй. Яваандаа нэг л мэдэхэд бичих хэвшил овоо болчихно. Ингэхгүйгээр гадаад хэлийг зав зайтай болсон үед, нэг л мөсөн сайн сурчихаад бичдэг болно гэвэл хэзээ ч бүтэхгүй хэрэг. Тэгэхээр *хийн сурах, суран хийх* арга л чухал даа гэж сануулан захидаг байж билээ. Бас бидний монголчууд цөөхүүлээ, хийх ажил их болохоор алин болгон гадаа гандаж, хөдөө хөхөрч явдаг малчин түмнийхээ хүзүүн дээр зайдлаж, тэдний хүч хөрөнгөөр гараа угааж байх билээ!. Нэг хэл үзнэ гээд л улсын мөнгө урасхалгүй бие дааж үзээд, цалин авч байгаа ажлаараа хязгаарлалгүй, ард түмэндээ хэрэгтэй өгөөжтэй зүйлийг л *хийн сурч, суран хийхээс өөр арга байхгүй шүү* гэдэг сургамжийн үг нь одоо ч санаанаас гардаггүй. Миний хоёр гол ном, бас бус өгүүлэлүүд бол тухайн цагт сэдэвийн хувьд батлагдах боломжгүй, тэгээд ч төлөвлөгөөнөөс гадуур цалин хөлсгүй бичсэн бүтээл билээ.

Одоо ялангуяа манай залуучуудын олонтаа ярьдаг "чөлөөт цаг" гэдэг зүйл багшид минь лав байгаагүй юм. Бүтээл туурвилы нь ерөнхийд нь авч үзэхүл эрдэмтэн, зохиолч, орчуулагч сурган хүмүүжүүлэгч сэтгүүлч гэсэн наад зах нь таван хүний ажил мэргэжлийг ганц биеэрээ хийж ирсэн байх бөгөөд тэр таван салбараар тус тусад нь юу хийж вэ? гэвэл биеэ даасан нэг эрдэмтэн, нэг зохиолч, нэг орчуулагч, нэг багш, нэг сэтгүүлч хүний нэг насаараа хийснээс чанар чансаагаараа ч, хэмжээгээрээ ч, тоогоороо ч дорд орохгүй. Гэтэл ганц биеэрээ энэ бүхнийг хийсэн шүү дээ гэж бодоход санаа саванд багтмааргүй. Энэ бүхэн бол дээр өгүүлсэн "чөлөөт цаг" гээч юм байгаагүйн нэг нутлагаа буй заа. Ерийн хүмүүний хүчнээс хэтийдсэн энэ их ажлыг хэрхэн гүйцэлдүүлж байв аа? Олон үзүүрт ажлыг хэд хэдэн машин дээр зэрэг эхлэж сеелжүүлэн хийдэг байсан нь алжаалы нь тайлдаг байсан төдийгүй номоо хийж л байх нь түүний бие сэтгэлийн жаргал нь болдог байлаа. Арав гаруй жил нэг байранд сууж, ойр дотно байсны хувьд зах зухаас нь мэдэх болсноосоо өгүүлэхэд өглөөнөөс шөнө дүл болтол олон үзүүрт ажлаа салаавчлан ээлжилж хийдэг байсан нь нэг бодоход алжаалы нь багасгадаг байсан байж болзошгүй боловч яс маханд төрсөн хүний хувьд ядрах зүдрэхээс яав ч ангижруулаагүй нь лавтай. Өдөрт охорхон боловч хэдэнтээ гарч, өвөл ч гэсэн дан цамцтай салхинд зогсож байдагсан. Тийнхүү салхинд зогсож байхдаа ч гэсэн зүгээр байлгүй хүүхэд багачуул хөл гараа зүсчихвий гэж зам дээрх шилний хагархай, чулууг түүж хогийн саванд хийдэг байсныг тэр хавийнхан одоо ч мартаагүй буй заа. Хэдийгээр үргэлжийн их ажилтай байсан ч очсон уулзсан хэнийг ч болов хойрго цааргагүй, үгий нь соносч, цаг хайрлалгүй ярьж хөөрч, үзүүштэй олдохгүй номы нь хүртэл түр хэрэглүүлж, зөвлөгөө сургаалаа хайрладаг, хүүхэд үүхэд хэн боловч захиа бичихэд заавал хариу илгээдэг байсныг үгүйсгэх хүн байхгүй биз ээ.


Зөв юм бүхэн буруу болж, зөөлөн бүхэнийг хатуу гэдэг байсан зүдэг харанхуй цагт, монголын төр зүтгэсэн хүндээ босго өндөр гэдэгчилэн шударгуу олон хүний хувь заяа буруугаар эргэж байсан боловч хүн хүний зан чанар харилцан адилгүй, түүнээс үүдэж хувь тавилан ч өөр өөрөөр шийдэгдэхэд хүрч байсан болохоор багш минь бодгали хүний хувьд хүмүүний гол ёсон, мөс чанараар ямар хүн байв гэдэг талаар бодол эргэцүүлээ гуравдахи удаа дэлгэрүүлэн ийнхүү толилуулах таатай боломж энэ жил тохиожээ.

Багш маань бага идэрээсээ бие сэтгэлийн алжаалаа умартан ном эрдэмээ буйлуулсан хүн. Тэгээд ч "Залуудаа махаа идвэл өтлөсөн хойно шөл ууна" гэж олонтаа захидагсан. Энэ үг нь цагийг дэмий хоосоор нөхцөөж, зугаа цэнгэлээс өөр алс хэтээ үл бодогч одоогийн олон залуусын чихээр ороод зогсохгүй тэдэнд сургамж болоосой гэж эрхгүй бодогддог. Хоол ч гэсэн ихдэхээрээ хор болдог. Монголчуудын "жаргал ихэдвэл зовлон болно" гэдэг гүн ухаан үүнтэй холбоотой.

Багш маань нэгэнт залуудаа сонгодог суурь боловсрол олж, үзэж унших юмаа амжуулан банжиж эрдэм нь буйлчихсан болохоор бүтээлээ туурвих нь аль хэдийнэ цагааширчихсан байсан нь мэдэгддэгсэн. Юм бичихдээ ноорог навтарга хийж цаг цаас үрдэггүй, монгол болон орос, франц, англи, герман, польш, чех зэрэг гадаад хэлээр шууд машин дээрээ эхлэдэг байв. Өдөрт хийх ёстой гэсэн хэмжээ дамжаатай, нойр хоолоо хасан байж түүнийгээ заавал гүйцээдэг зантай; хөдөө гадаа явсан ч үүнийгээ баримтлана. Нэг жишээ хэлэхэд, 1964 оны зун Хөвсгөлийн үүрийн Урианхай нараар орох гэж Хатгалаас Ханх хүртэл усан онгоцоор, Ханхаас моторт завиар баахан явж, маргааш өглөө нь нар мандмагц мориор Үүрийн голыг сүлжин, зайвар замаар уул хэжин явсаар өдөржийн газрыг туулж нар шингэх алдад товлосон хотондоо очсон билээ. Тэгэхэд бид мэт нь моринд агсагдаад сууж ч чадахгүй ядарч байхад багш минь буусан гэртээ завиан суугаад бүрий болтол чех хэлнээс орчуулгаа хийж "төлөвлөсөн" ажлаа дуусгаж суусан нь одоо ч нүдэнд харагдах шиг болдог. Бороо хариулдаг хүн "Цув цээжинд буй" гэдэгчилэн багшийн маань цээжинд олон хэлний толь бичиг боть ботиороо бэлэн болохоор илүү дутуу ном дэвтэр тээж явах хэрэг гардаггүйсэн.

Судлагааны хэрэглэгдэхүүн, бичиг цаас, ном дэвтэрээ хэрхэн хадгалдаг хүн байв? гэж үү? Тэр үед хамгийн найдвартай арга бол цаасан дээр тэмдэглэж авах явдал байсан. Багшид маань түүртэх юм нэгээхэнбээр байхгүй. Ерийн яриаг монгол бичгээрээ хэлсэнтэй нь зэрэг бичнэ. Нутгийн аялгууны онцлогийг латин галигаар тэмдэглэнэ. Сонор нь авиа, аялгууны онцлогийг маш нарийн ялгана. Өөрөө түүнтэй нь яг адилхан дуудаж лавладаг байлаа. Юмыг дүрслэж зурахдаа бас сайн. Нэгэн жишээ гэвэл:

Судар Бичигийн Хүрээлэнг Шинжлэх Ухааны Хүрээлэн болж өргөжихөд, бадмалянхуа суурин дээр таван хошуу болон мунхагийн харанхуйг таслан арилгагч оюун ухааны юлдыг дүрслэж, Монгол Улсын Шинжилэхүй Ухааны Хүрээлэн гэдэг үгийг тойруулан бичээд, "Таван тивд нэр алдар бадаран дэлгэрч, Дотоодод эрдэм ухаан хөгжин гийх"-ийн дэмбэрэл төгссөн хэвийн тэмдэг (эмблем) болгомуй гэж мутараараа зуран үйлдсэн нэгэн хуудас одоо хүртэл хадгалагдан үлджээ.



Хөдөө гадаа, гадаад оронд хаа ч гэсэн хамт явахад аливаа ажил бүтэхгүй байна гэж даан ч нэг байхгүй. Монгол ардын сэцэн үгэнд “Буян заяахад хийморь заяана” гэдэг үг бий. Багшид маань ном эрдэм хурасны хажуугаар аман хишиг, нүүрийн буян, хийморь лундаа тэгш заяасан хүн байсан даа. Харин үүнд нь атаархдаг хүн цөөн бус байсан гэдэгт баттай итгэж байна. Амьдралынхи нь сүүлийн хориод жилд элдэвээр муучлан, шүүмжлэх явдал захаас аван гарахад шавийнхи нь хувьд сэтгэл зовох (тэхдээ би өөрийнхөө тухайд зовсон хэрэг биш, багш шавийн барилдалгатай болсондоо эргэлзсэн бодол нэг ч удаа толгойд ороогүй гэдгийг багшийн минь сүлд харж байгаа) боловч өөртэй нь уулзахад номын гэгээ гийсэн хийморилог царайг нь хараад л сэтгэлийн эмзэглэл оргүй арилдаг байсанд би одоо хүртэл гайхдаг юм. Польшийн монголч эрдэмтэн С. Шинкевичийн “Профессор уулзаж учрах бүрийд ухаалаг мэргэн зөвлөгөө, марган сэнхрүүлэх чадвараараа аргагүй нэг бишрүүлж, хэнд ч ялагдашгүй, хэзээ ч үхэшгүй юм шиг санагдуулдаг асан” гэж бичсэнийг нь үзээд багшийн минь тэр чанар нь зөвхөн надад ч биш, бусад хүмүүст ч адилхан нөлөөлдөг байж дээ гэж санадаг.

1970 онд “Таны үргэлж санаж явдаг ямар мэргэн үг байдаг вэ? гэж асуусан сэтгүүлчид “Чехийн Ян Хүсийн үхсэн ч үнэнчээр явсаар үх! гэдэг үгийг үргэлж санаж явдаг” гэж хариулсан байдаг. Үнэнчээр явна гэдэг аливаа хүний дагаваас зохих нэгэн гол ёсон мөн бөгөөд индэр дээрээс ярьж уриалахад ёсны доторхи амархан эгэл зүйл мэт боловч чухамхүү ажил амьдрал дээр болохоороо нэн эртнээс өдгөө хүртэл, ялангуяа зор эзэрхэгчийн үед асар их зориг тэвчээр хөвчлүүлсэн өцөд зүйл байдаг ажээ. Тэгээд ч манай ардын сэцэн үгэнд “Үнэн үг хэлсэн хүнд хүн өштэй, үхэр унасан хүнд нохой өштэй” гэдэг үг гарчээ. Үүн лүгээ нэгэн адил утгатай “*Veritas odium parit, obsequium amicos*” буюу үгчилж орчуулбал “Үнэнч шударгуу нь дайсныг, зусар бялдууч нь нөхрийг төрүүлмүй” (оросоор “*правда глаза колет*” гэж орчуулдаг) гэдэг үг эртний латин хэлэнд байдаг нь бас л түүний баталгаа буй заа. Хэрвээ иймгүйсэн бол үнэний тухай тэгж их ярихын ч хэрэггүй, бүх юм ном зүйгээрээ л байхсан биз ээ. Харин цаг хугацаа гэгч үнэн мөнийг ялгаруулагч ганц шударгуу шүүгч ажээ. Үнэн мөн ялгарахдаа даан ч удаан, их төлөв хүний нас хүрдэггүй нь даан ч харамсалтай. Энэ хугацааг богиносгож болдогсон бол ёстой нэг өөрчлөлт шинэчлэлт болно доо гэж санагддаг.

Ри багшийн маань үйл амьдрал нь үргэлж санаж явдаг байсан Ян Хүсийн үгэнд амаараа ч, ажлаараа ч хүрч байсныг бүхий л талаараа нутласаар ирснийг юмны наад цаадыг бодотой зөв дүгнэж цэгнэдэг олон түмэн мэдсээр ирсэн, харин зор эзэрхэгчдийн зохион найруулсан хиймэл жүжгийн үйл явдалд “итгэж” байсан хүмүүс сая ойрмогхоноос нарийн учир начирыг ойлгож байна даа.

Одоо бид ам ажлын нэгдлийн талаар мөн ч их ярьсаар байгаа хирнээ нэг л сайн нэгдэж өгөхгүй байна. Багшийн маань ном зохиол дотор “*монголын за андгаар буй заа*” гэдэг хэллэг олонтаа дайралддаг. Энэ нь монгол хүн “за” л гэсэн үг бол андгай тангараг тавьсантай агаараа нэг гэсэн утга. Тийм ч учраас монголчууд юм болгон дээр барин тавин андгай тангараг тавиад байдаггүй, онцгой ганц нэг зүйл дээр тангараг тавьсан бол насан туршдаа баримталж, тангараг няцсанаас үхсэн нь дээр гэж үздэг байсан билээ. Одоо бол үүнээс огт өөр болчихсон шиг санагддаг. Багшийнхаа ажил үйлсийг бодоод байвал, бидний ярьсаар байгаа ам, ажил хоёрын нэгдэл гэдэг ойлголт нь утгаа дээр дурдсан ам, ажил гэдэг хоёр гишүүний нэгдэл биш, гурван гишүүний нэгдэл байсан бол огт өөр байх байж дээ гэж бодогддог. Үүнд, хамгийн гол гуравдагч гишүүн нь дотоод үнэн санаа болой. Дотроо бодсон үнэн санаа, амнаас гарч байгаа үг хоёр нийлсэн цагт л ажил бүтнэ. Нэгийг санаанд нөгөөг хэлсэн бол өнөөх л сайхан хоосон яриа л үлдэнэ дээ. Санаандаа нийцээгүй юман дээр удирдлагын сэтгэлд нийцүүлж сайхан ярихын жишээг бид олон жил сонслоо. Тэгээд л ам, ажил хоёр нийлж байсангүй.

Ингэж бодохоор дотор санасан санаа, түүнтэйгээ тохирсон үг хэлж ажил болгоно гэдэг бол шударгуу байхын үндэс ажээ. Тэгээд ч монгол ардын сэцэн үгэнд байдагчлан “*Ноёнтой өстэй бол хонгогүй, нохойтой өстэй бол хормойгүй*” болдог цагт цэгнэсэн бодол, дүгнэсэн үг, гүйцэтгэсэн ажил гурваа нэгэн голдиролд оруулна гэдэг нь зориг тэвчээр шаардсан, арал шөрмөс заасан

амаргүй явдал байсан бөгөөд тэгж чадсан хүн амь нас, нэр төр, хувь заяа, аж амьдралаараа ямагт дэнчин тавьж хохирсоор ирсэн. Үүний бие бодотой сонгодог жишээ бол заримдаа хүнийг магтахдаа *"Хүнийг их бага гэж ялгадаггүй хүн"* хэмээж ярьж, дүгнэж сурсан байна. Энэ "үнэлгээ"-г хэн дээр яриад байна вэ? гэдгийг сайтар бодож үзвэл гол төлөв "том" буюу дарга нарын тухайд ярьж, том дарга хүн үнэнээсээ ч юм уу, засдаг өнгөөр ч юм уу, доод хүнээ тоомсорлож үзлээ гэж үзээгүй юмаа үзсэн мэт олзуурхаж хөөрч баясан ийнхүү ярьдаг болсноо бид анзаарахгүй болчихсон юм уу даа гэж санагддаг. Чухамдаа бол энэ үнэлгээ маань энэ утгаараа зохистой эсэхийг бодох цагт хэдийнээ тулж ирээд байна даа. Бидний ийнхүү хөөрч баясан, олзуурхаж ярьдаг дүгнэлт маань саяхи утгаараа, түмнээс хол "тасарсан" удирдагч, дарга нарын ааш занг ёсны доторхи хэрэг гэж хүлээн зөвшөөрөөд сурчихсан байсныг л баталж байгаа баримт буюу. Жинхэнэ хүний ёсны үүднээс, нөгөө талаас нь бодож үзэхүл, огт өөр ухагдахуун гарч ирнэ. Энэ жишигээр авч яривал, ялангуяа зор эзэрхэгчийн үед харин ч хүний гол ёсны дотор байваас зохих ёстой боловч нэн ховордсон, аливаад нухацтай ухаалаг хандаж, сэтгэлийн тэнхээ заасан хүний тухайд л хамааруулбал зохилтой. Ингэж ухаарвал ер энгийн хүн үнэнийг зөвхөн шивнэж ярилгүй үнэн мөнийг үнэнд нь нийцүүлж ухаалаг бодол дүгнэлтээ хэнбэгуайн ч хүсэл санаанд захируулалгүй зүрхлэн хэлж, зориглон ажиллаж, санаачлан бүтээж ирсэн, чухам тийм хүнийг л бид *"хүнийг их, бага гэж ялгадаггүй хүн"* гэж үнэлбэл шударгуу ёсонд илүү зохицох болно. Чухам энэ талаасаа л *"Хүнийг их, бага гэж ялгадаггүй хүн"* гэдэг үг талийгаач багшид маань хамаарна. Академичаас үндэснийхээ хэл бичиг, соёл боловсрол, жинхэнэ шинжлэх ухааныг дэлгэрүүлэн хөгжүүлэх, нийгмийн шударга ариун ёсыг тогтоох гэсэн нэгэн үзүүрт сэтгэлээр Ю. Цэдэнбал, Н. С. Хрушев, Мао Зе-Дүн, Л.И. Брежнев зэрэг бас бус "дээд" дарга нарт бичсэн захиа захидал, хэлсэн үг, тавьсан санал нь энэ бүхний нутлагаа, бас зориг зүрхтэйхнх нь ч баталгаа буюу.

Тэгвэл яагаад насан туршид нь "томчууд" болон зарим "эрдэмтэн" ад үзэж байв аа? гэдэг асуулт зүй ёсоор гарна. Үүний гол учир гэвэл *"Үнэн үг хэлсэн хүнд, хүн өшөөтэй, үхэр унасан хүнд нохой өшөөтэй"* гэдэг монгол ардын сэцэн үгийг санахад л хариулт нь тодорхой болоод ирэх вий. Багш маань биеэ үгүйлдэггүй, албан тушаалдаа эрдэн сагсуурсан хэнийг ч болов гартаан ичээх үгийг шууд хэлчихдэг байсан нь эрх мэдэл бүхий нэг хэсэг "далд" дарга дайсаныг төрүүлсэн юм. Бас ном эрдэмээр мариухан хэнийг ч болов хоосон мэдэмхийрээд байхад нь амы нь таглах үг хэлчихдэг байсан нь хэсэг "эрдэмтэн"-ий дургүйцэлийг хүргэсэн хэрэг. Эрдэм чадал, оюун ухаанаараа бие даан явах тэнхэлгүй нэгэн хэсэг нь тэднийг аялдан дагаж амь зуухаас өөр хэрхэх билээ.

Өнгөрүүлсэн амьдрал ахуйнхаа талаар багагүй дурсан ярьдаг боловч яг тухайн үеийнхээ хяхаа хавчилгын талаар тэр бүр яриад байдаггүй, хийх юмаа л хийж суудаг, сэтгэлийн гүн тэвчээртэй хүн байсан. Түүний зохиол бүтээлд *"цээжинд ассан түймэрийн утааг хамараараа бүү гарга!"* гэдэг үг нэг бус удаа дайралддаг нь дэмий хоосон хэлчихсэн үг яав ч биш буй заа.

1976 онд *"Намын амьдрал"* сэтгүүлд Ринчен багшийн маань талаар гарсан эзэн зохиогч үгүй гүжирийн өгүүлэлд эцэг эхийнхнх нь талаар мөн л эсэргүү, наймаачин, шоронд орж байсан гэх зэргээр зүсэн зүйлээр элдэвчилэн бичсэн зүйл буй. Багш минь нэгэн удаа ярианы далимд ээжийнхээ талаар Октябрийн хувьсгалын дараахан орос оронд өлсгөлөн гуйланчилал хэтийдэхэд Зөвлөлийн Засагаас нийт улс даяар хүмүүсийн үнэ цэнэтэй бүхий л зүйлийг хураан авах зохион байгуулалттай ажил болж Буриад газар ч эмэгтэйчүүдийн алтан ээмэг, бөгжийг булаан авч эхлэсэн бөгөөд юмаа өгөхгүй гэсэн хүмүүсийг ангийн дайсан гэж Хар гэрт хорьдог байсан бөгөөд түүнд ээж минь нэгэн удаа өртсөн гэж ярьж байсан билээ. Түүнээс гадна 1940 хэдэн оны эхээр МУИС-ийн баруун талын зам засах ажилд оролцож байсан хоригдол лам нарт нэгэн авгай дандаа нууцаар талх шидэж өгдөг байсан, түүний нь нууж байгаад орой хувааж иддэг байсан, дараа нь тэр авгайг өөр хоорондоо "эжий" гэж нэрлэх болсон тухай, хожим учир нь мэдвэл Ринчен багштаны ээж нь байсан тухай Гандангийн хэд хэдэн өвгөн лам хуучласан гэж Шашины Дээд Сургуульд хичээлийн эрхлэгчээр ажиллаж байсан Д. Дамба 1999 оны хавар надад ярьсан бөлгөө. Энэ мэтээр дурдсан шүүмжийн өгүүлэлд өөрийнх нь талаар болон эцэг эх, ах дүү нарынхнх нь талаархи дурдсан зүйл огт үндэсгүй болохыг Ри багштанаас Ю. Цэдэнбал, Л. И. Брежнев нарт бичсэн захидал, мөн түүнчилэн буриадаас Ю. Цэдэнбалд ирүүлсэн, учир мэдэх хүмүүсийн захидал зэргээс тодорхой харж болно.

Ринчен багшаныг 1977 онд тэнгэрт халихад нь гашуудлын мэдээг нэлээд хэл ам болон байж *Утга зохиол, урлаг* сонинд арга буюу тавьсан бөгөөд тэр мэдээг сайтар эргэцүүлэн үзвэл дээд сургууль төгсөөгүй..., ...цагаач маягаар монголд ирсэн ... гэх зэрэг ойлголт авахаар байдаг бөгөөд үүнийг ч тэр үед нэг бус хүмүүс нууцхан ярьдаг байлаа. Тэрхүү гашуудалын мэдээг бичилцэсэн хүн одоо шавь нь гээд л явж байна. Түүнээс 9 жилийн дараа дэлхийн социалист систем суларсан үед буюу 1986 онд Чехословакийн нэрт монголч эрдэмтэн Павел Поуха *Архив Ориентали* гэдэг ЭШ-ний улирал тутамын сэтгүүлийн дугаарт (*Archiv orientalni*, 2 volume 54/1986, *Quarterly Journal of African, Asian and Latin American Studies*, Academia Praha, pp. 168-179) хэвлүүлсэн *Life and Work Byambin Rinchen* гэдэг томоохон өгүүлэлдээ уг гашуудалын мэдээг англиар орчуулж үг бүрт нь баримт түшсэн дэлгэрэнгүй тайлбарыг зүүлт маягаар нэмэж үнэн байдлыг тодруулан нийтлүүлсэн нь багшийн маань аж амьдрал, эрдэм ном, мөн чанарыг мэддэг гадаадын эрдэмтэд, олон нийт уг гашуудалын мэдээг сэтгэл дундуур хүлээж авсаны бодат баримт гэж хэлж болно².


1990 оны 12-р сард багшийн маань эснэсэний 85 жилийн ойг улс даяар тэмдэглэсэн бөгөөд гүйж хөөцөлдөх зэрэг бэлтгэл бүх ажилд миний бие оролцож явсаны хувьд, манай академийн олон шатны удирдалгын дотор цаанаа тийм ч дуртай биш хүмүүс мэр сэр байсан ч нэгэнт цагийн амисхал өөр болсоны учир арга буюу саад хийж чадаагүйг мэднэ. Харин ШУА-ийн дэд ерөнхийлөгч академич С. Норовсамбуу, нийгэмийн ухааны салбарын эрдэмтэн нарийн бичигийн дарга Гомбо нар бололцооныхоо дээдээр дэмжиж гүйцэлдүүллсэнд одоо ч гэсэн гүнээ талархаж явдагаа энэ ташрамд хэлэх сайхан боломж бүрдсэнд нэн баяртай байна.

Багш минь "Цогт тайж" хэмээх кино зохиолоороо 1946 онд (тэр үед Чойбалсангийн гэж байсан) Төрийн шагнал хүртээд шагналын мөнгий нь бүтнээр нь эх орны дайны үед Ленинград (Петербург) хотын хамгаалалтад амь үрэгдсэн хүмүүсийн ар гэр, үр хүүхдүүдэд илгээж эрдэм сургасан хотынхоо өмнө хариу журамыг гүйцэтгэсэн, ХБНГУ-д хэвлүүлсэн 9 боть номынхоо шагналаар хэвлэлийн 4 машин авч ШУА-ийн Хэвлэх Үйлдвэрийн хаягаар шилжүүлсэн, гадаадад хэвлүүлсэн зохиолынхоо шагналын мөнгийг Вьетнамын өнчин хүүхэдүүдэд илгээсэн, жил бүр ШУА-аас унаа дуудаж ойр зуур хэрэглэхгүй гэсэн ном сэтгүүлээсээ Улсын Нийтийн Номын Санд үнэ төлбөргүй шилжүүлдэг зэрэгийг нь бодоход хувь хүний хувьд эдийн шуналд автаж, мөнгөний уналд унаагүй, өгөөмөр агуу сэтгэлтэн байжээ гэж эрхгүй санагддаг.

^{мэдлийн}
 Хүний эрхийн ~~эр~~ нийт тунхаг
 Нэгдсэн Үндэстний Ерөнхий Хурлаар
 1948 оны 12 дугаар сарын 10-нд байсан
 тунхаглалын.

² Профессор П. Поуха авгайн энэхүү дурсамж өгүүлэлийг академич Ринчен профессорын эснэсэний 95 жилийн ойд зориулж МУИС-ийн Монгол хэл соёлын сургуулиас гаргасан *Монголын судлалын эрдэм шинжилгээний бичиг*-ийн XVII(169) ботийн 3-14-р талд уг англи эхээр нь нийтлүүлсэн билээ.

1950 хэдэн оны гар бичмэлийнхи нь дотор Нэгдсэн үндэстэний Байгуулгын Ерөнхий хуралаар 1948 оны 12-р сарын 10-нд батласан "Хүний эрх мэдэлийн ер нийт тунхаг"-ийн бараг бүрэн монгол орчуулга байдаг бөгөөд үүнээс үзэхүл 1990-ээд он болтол социалист орнуудын хувьд, тэр дундаа Монголын энгийн олон нийтийн хувьд бараг мэдэж байгаагүй, 1990 хэдэн онд сая нэг монголчилосон гэх Хүний эрх мэдэлийн ер нийт тунхаг-ийн утга учирьг бүр эхинээс сайн мэдээд зогсоогүй хэрэгтэй хэмээн эх хэлээрээ орчуулж байсаны нь нутлагаа буюу.



Багш минь надад зарим ном, өөрийнхөө шинэ бүтээлээс байн байн хүртээж "Улс Монголоо нэрлүүлэх их эрдэмтэн болохын ерөөл талбива" гэсэн нэг л янзын үгийг мутарлан хайрладаг байсан асан. Молхи отгон шавь нь багшитаныхаа энэ ерөөлий нь ёсоор болгохсон гэж чармайсаар монголын судлалын эрдэмтэдийн тоос дунд дөчөөд жил эргэлт буцалтгүй явсаар байна.

Багшийнхаа эснэсэний нэгэн зуун жилийн ойгоор гэгээн дурасхалд нь зориулан эрдэмийнхи нь шим, номынхи нь буянаас хүртэлцсэн эгэл нэгэн шавийн хувьд бичиж буй энэхүү бяцхан дурсамж-эргэцүүлэлээ нэхэн бодвол, Ри багш маань:

Бүтээл туурвилын хувьд, наад зах нь нарийн мэргэжлийн таван хүний нэг насаараа тэр бүр хийж амжихааргүй ажлыг ганц биеэрээ эрдэм чадал зааж гүйцэлдүүлж иржээ.

Иргэний хувьд, ард түмэн, улс гэр, эх хэл, өв соёл, монгол зан заншилаа үнэн зүрх сэтгэлээсээ эрхэмлэн хүндэтгэж хайрлан хамгаалж ирсэн зоригтой эх оронч хүн байлаа.

Ринчен багшийн улс орноо гэсэн сэтгэлгэ нь зөвхөн монгол хэл бичиг, соёлоор хязгаарлагдаж байгаагүй нийгэмийн бүхий л салбартай холбоотой байсан юм. Ганц жишээ хэлэхэд, 1950 хэдэн онд Улаанбаатар хотын талаар Намын Төв Хороонд захиа бичиж, туурга тусхаар улсын нийслэл өөрийн гэсэн өвөрмиц өнгө төрхтэй байх ёстой байтал одоо барьж байгаа барилга байшин ЗХУ-ын Сибирийн захын хотын загвартай байна гээд *Элдэв-очир* кино театрын барилга гэхэд Черногов хотын *"Победа"* гэдэг кино театртэй яг адилхан байна гээд тэр байшингийн гэрэл зургийг нь хавсаргасан байдаг. Яг ийм санааг хожим Горбачев дарга Монголд ирэхдээ *"Танай Улаанбаатар манай Сибирийн нэг жижигхэн хоторхуу баригдчихсан юм. Үүнийг агуу их монгол түмний нийслэл шиг болгох хэрэгтэй"* гэж хэлж байсан гэдэг³.

Хүний гол ёсны хувьд, санасан санаа зөв, өнгөрүүлсэн зам шударгуу, өгүүлсэн үг үнэн бөгөөд тэр бүхэн нь бүтээсэн буянтай үйл ажилтайгаа ямагт нийцэж найрссан, шударгуу үнэний жишээг үзүүлсэн эрдэмтэн, зохиолч, орчуулагч, сурган хүмүүжүүлэгч, сэтгүүлч хүн байсан бөгөөд энэ бүх чанар нь эх орон, ард түмнийхээ эрх ашигийг гаргуунд гаргасан "удирдагч", тэдний гар хөл бологчдынхи нь санаанд нэгээхэн бээр таарч байгаагүй боловч эрүүл саруул ухаантай, шударгуу хүн ардын зүрх сэтгэлд үнэн мөнөөрөө оршсоор ирсэн, оршсоор ч байх болно заа!

2005 оны 11-р сарын 20-ны сайн өдөр,
Улаанбаатар хот.

³ Д-р Ц. Гүрбадам, "Түүний хөшөөг албаар босгох байсан..." - Mongol Express, 1996 N. 2 (07), IV тал.



1963 оны хавар шинжээний ангиар явах үес
Хэнтий аймагт:

Оюутан Жамбал, Шагдарсүрэн,
ЭШ ажилтан Жень-Батнасан нарын хамт

(Гэрэл зураг татсан доктор Б. Сумъяабаатар)